

**ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 09 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг нарын 13 гишүүнээс 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах, хяналт тавих тогтолцоог оновчтой болгох, мэргэжлийн удирдлагаар хангах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлагыг өндөржүүлэх, эрүүл хооллолтыг дэмжих, хэрэглэгчдэд хоол, хүнсээ зөв сонгох, эрүүл мэндээ хамгаалах соёлыг төлөвшүүлэх, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хоолны цэсийн шошго, зар сурталчилгаа, гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зууш, түргэн хоолны газар, хуушуурын цэгт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдох стандартыг мөрдүүлэх, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг татварын бодлогоор дамжуулан хязгаарлах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид өөрт хамаарах үе шатанд тохирох зохистой дадлын стандартыг мөрдүүлэх зэрэг өөрчлөлтийг тусгасан бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагаас холбогдох зардал гарахаар тусгажээ.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан төсөлд ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний пестицидийн үлдэгдэл, малын гаралтай бүтээгдэхүүн, мах, сүүнд антибиотикийн үлдэгдлийг хянах асуудлыг тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь салбарын хяналтын чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж байгаа эсэх, хүн амын нийтийн хэрэгцээнд нийлүүлэх махыг стандартын шаардлага хангасан нядалгааны төвөөр, үйлдвэрийн аргаар хэрэглэгчидэд хүргэж байгаа эсэх, гар аргаар нядалгаа хийдэг махны зах, мах нядалгааны газарт тавих хяналтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга төсөлд хүнсний аюулгүй байдлыг хангахад оролцогч талуудын хариуцлага, хяналтыг хэрэгжүүлэхэд анхаарах, төрийн болон орон нутгийн, хувийн сорилын лабораториудын чадавх, ажиллах боломж, хүний нөөцийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, хэлэлцүүлгийн шатанд сайжруулах боломжтойг дурдаад, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, тээвэрлэлт, хадгалалтын асуудлыг цогцоор нь шийдэх тогтолцоог бүрдүүлэх, хил, гаалиар орж ирж байгаа хүнсний импортын бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах асуудалд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулах зохицуулалтыг иж бүрэн тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж, төсөлд тусгасан Хүнсний хяналт, зохицуулалтын газар бий болгох асуудалд Засгийн газраас санал авсан эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Харин Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжих эсэх асуудлаар цөөнх болсон бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.14-т заасны дагуу энэ асуудлаар нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүсэлтээ илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Б.БЕЙСЕН

